

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2023 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН



УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТАМГЫН ГАЗАР

2023 ОНЫ 12 ДУГААР САРЫН 09-НИЙ ӨДӨР, БЯМБА ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

ХҮНДЭТГЭЛИЙН
ХУРАЛДААН

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

*Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дээрх
QR кодыг уншуулан танилцах боломжтой.*

**ХҮНДЭТГЭЛИЙН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН
АГУУЛГА**

2023 оны 12 дугаар сарын 09-ний өдөр, Бямба гараг

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	1
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	2 - 3
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	4 - 19
<i>1. Хүний эрхийн түгээмэл тунхаглал батлагдсаны 75 жилийн ойд зориулсан Улсын Их Хурлын хүндэтгэлийн хуралдаан</i>	4 - 19

**Монгол Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы
12 дугаар сарын 09-ний өдөр /Бямба гараг/-ийн Хүний эрхийн түгээмэл тунхаглал
батлагдсаны 75 жилийн ойд зориулсан Улсын Их Хурлын хүндэтгэлийн
хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар хүндэтгэлийн хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 72 гишүүнээс 48 гишүүн хүрэлцэн ирж, 66.7 хувийн ирцтэйгээр хуралдаан 11 цаг 40 минутад Төрийн ордны “Их хуралдай” танхимд эхлэв.

Томилолттой: Х.Баделхан, Н.Наранбаатар, Ц.Сэргэлэн, Д.Цогтбаатар,
Л.Энх-Амгалан, Б.Энхбаяр;

Чөлөөтэй: Ё.Баатарбилэг, Ц.Даваасүрэн;

Тасалсан: Ш.Адьяа, А.Адъяасүрэн, Г.Амартүвшин, Ц.Анандбазар, Т.Аубакир,
Э.Бат-Амгалан, С.Батболд, Х.Булгантуяа, С.Ганбаатар, Х.Ганхуяг, Г.Дамдинням,
Т.Доржханд, Ц.Мөнх-Оргил, Ц.Сандаг-Очир, Ч.Ундрам, Ч.Хүрэлбаатар, Ж.Эрдэнэбат;

Хоцорсон: С.Амарсайхан – 02 минут, Б.Баттөмөр – 07 минут, Б.Бейсен – 22
минут, Б.Жавхлан – 11 минут, Д.Өнөрболор – 01 минут, Ш.Раднаасэд – 12 минут,
О.Цогтгэрэл – 04 минут, Б.Энх-Амгалан – 02 минут.

**Нэг.Хүний эрхийн түгээмэл тунхаглал батлагдсаны 75 жилийн ойд
зориулсан Улсын Их Хурлын хүндэтгэлийн хуралдаан**

“Их хуралдай” танхим дахь Төрийн далбааны дэргэд хүндэт харуул зогсож, Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар, Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ нар суудлаа эзэлсэн байлаа.

Танхимын баруун болон зүүн дэлгэц дээр “Хүний эрхийн түгээмэл тунхаглал батлагдсаны 75 жилийн ойд зориулсан Монгол Улсын Их Хурлын хүндэтгэлийн хуралдаан, 2023.12.09” гэсэн үгийг кирилл болон уйгуржин Монгол бичгээр бичсэн байв.

“Их хуралдай” танхимын баруун талд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Д.Энхбат, Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга Д.Сүнжид, Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга Р.Онончимэг, Улсын Их Хурлын дарга асан Н.Энхбаяр, Улсын Их Хурлын дарга асан С.Төмөр-Очир, Улсын Их Хурлын дарга асан Д.Дэмбэрэл, Монголын Хуульчдын холбооны Ерөнхийлөгч П.Одгэрэл, Санхүүгийн зохицуулах хорооны дарга Д.Баярсайхан, Сонгуулийн ерөнхий хорооны дарга П.Дэлгэрнаран, Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн Б.Энхболд, Г.Нарантуяа, С.Дондов, Х.Мөнхзул, Хүний эрхийн Үндэсний Комиссын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүн Я.Цэлмэн, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хууль тогтоомж, нийгмийн оролцооны асуудал хариуцсан мэргэжилтэн Б.Болороо нар;

“Их хуралдай” танхимын зүүн талд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, Дэд дарга Ц.Батбаатар, Дотоод аудитын албаны дарга бөгөөд дотоод аудитор Я.Баттогтох, Хууль, эрх зүйн газрын дарга Н.Мягмар, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Г.Агар-Эрдэнэ, Цахим парламент, инновацын газрын дарга С.Тамир, Цахим парламент, инновацын газрын Мэдээллийн технологийн хэлтсийн дарга Г.Лхагвадорж, Захиргаа, хүний нөөцийн хэлтсийн дарга Б.Пүрэвдагва, Санхүү, хангамж

үйлчилгээний хэлтсийн дарга Б.Лхагвасүрэн, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Ж.Чимгээ, Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Ш.Ариунжаргал, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Л.Лхагвасүрэн, Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул, Төсвийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Э.Алтанзул, Гадаад харилцааны хэлтсийн дарга С.Даваадаш, Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн Ажлын албаны дарга Б.Энхмөнх нар;

Мөн Монгол Улсад суугаа Дипломат төлөөлөгчийн газрын тэргүүн нар, Нэгдсэн Үндэстний Байгууллага, түүний төрөлжсөн болон Олон улсын байгууллагын Монгол Улс дахь суурин төлөөлөгчид, зочид урилгаар оролцов. /нэрсийг хавсаргав/

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар Хүний эрхийн түгээмэл тунхаглал батлагдсаны 75 жилийн ойд зориулсан Улсын Их Хурлын хүндэтгэлийн хуралдаан нээснийг мэдэгдэв.

Танхимд Монгол Улсын Төрийн дуулал эгшиглэж, Улсын Их Хурлын дарга болон хуралдаанд оролцогсод босож хүндэтгэл үзүүлэв.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар үг хэлж, Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүний эрхийн дээд комиссар, ноён Фолькер Тюрк, Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий ассамблейн 78 дугаар чуулганы дарга, ноён Деннис Франсис, Нэгдсэн Үндэстний Байгууллагын суурин зохицуулагч, ноён Тапан Мишра, “Эмнести Интернэйшнл” олон улсын байгууллагын Ерөнхий нарийн бичгийн дарга, хатагтай Агнес Калламард нар цахимаар мэндчилгээ дэвшүүлэв.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар хүндэтгэлийн хуралдаан өндөрлөснийг мэдэгдэв.

Хүндэтгэлийн хуралдааны зохион байгуулалтыг Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Хуралдаан зохион байгуулах хэлтсийн дарга Н.Наранцогт, мөн хэлтсийн шинжээч Ш.Мөнхцоож, С.Энхзаяа, ахлах мэргэжилтэн С.Золжаргал нар хариуцан ажиллав.

Хүндэтгэлийн хуралдаан 42 минут үргэлжилж, 72 гишүүнээс 47 гишүүн хүрэлцэн ирж, 65.3 хувийн ирцтэйгээр 12 цаг 22 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ЕРӨНХИЙ НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА

Д.ЭНХБАТ

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ
ШИНЖЭЭЧ

Ц.АЛТАН-ОД

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2023 оны 12 дугаар сарын 09-ний өдөр,
Бямба гараг
Төрийн ордон “Их хуралдай” танхим
10 цаг 40 минут.

ХҮНДЭТГЭЛИЙН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Г.Занданшатар: Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ, хүндэт зочид оо,

Та бүхний энэ өдрийн амгаланг айлтган танхимд мэндчилгээ дэвшүүлье.

Хүний эрхийн түгээмэл тунхаглал батлагдсаны 75 жилийн ойд зориулсан Улсын Их Хурлын хүндэтгэлийн хуралдаан Төрийн ордны “Их хуралдай” танхимд эхлэхэд бэлэн боллоо.

Хүндэтгэлийн хуралдаанд Монгол Улсын Ерөнхий сайд Лувсаннамсрайн Оюун-Эрдэнэ, Засгийн газрын гишүүд, үе үеийн Улсын Их Хурлын дарга нарын төлөөлөл, Улсын Их Хуралд ажиллаад шууд тайлагнан хариуцдаг байгууллагуудын дарга, удирдлагууд, мөн Монгол Улсад суугаа дипломат төлөөлөгчдийн газрын тэргүүн нар, Нэгдсэн Үндэстний Байгууллага, түүний төрөлжсөн олон улсын байгууллагуудын Монгол Улс дахь суурин төлөөлөгчид, Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүд, иргэдийн төлөөлөл уригдан оролцож байна.

Улсын Их Хурлын Хүндэтгэлийн хуралдаан нээснийг мэдэгдье. /алх цохив/

(Хүндэтгэлийн хуралдаан нээснийг мэдэгдэн алх цохимогц Төрийн дуулал танхимд эгшиглэв.)

Эрхэм хүндэт Монгол Улсын Ерөнхий сайд аа,

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Хүндэт зочид, хатагтай, ноёд оо,

Та бүхний энэ өдрийн амгаланг айлтгаж, Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблейгаас Хүний эрхийн түгээмэл тунхаглалыг баталсны 75 жил, Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүний эрхийн Дээд комиссарын алба байгуулагдсаны 30 жил, Хүний эрхийг хөхиүлэн дэмжих, хамгаалах үндэсний байгууллагуудын Парисын зарчим батлагдсаны 30 жилийн ойн мэндчилгээг өргөн дэвшүүлье.

1948 оны 12 дугаар сарын 10-ны өдөр Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблейгаас баталсан Хүний эрхийн түгээмэл тунхаглал нь дэлхийн хаана байгаа, хэн байхаас үл хамааран хүн бүр угаас заяасан үнэ цэн, нэр хүнд, нандин чанар, салшгүй эрхтэй гэдгийг хүн төрөлхтний түүхэнд анх удаа тунхаглаж, хүлээн зөвшөөрсөн түүхэн ач холбогдолтой баримт бичиг юм.

Түүнчлэн Хүний эрхийг хамгаалах нь орчин үеийн парламентын нэн чухал чиг үүрэг болохыг Олон Улсын Парламентын Холбоо тунхаглаж, парламентуудыг энэ чиглэлд санаачилгатай ажиллахыг уриалсан.

Монгол Улс 1961 онд Нэгдсэн Үндэстний Байгууллагын бүрэн эрхт гишүүн болсон.

Тэр үеэс хойш Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүний эрхийн конвенц болон нийт **299** олон талт олон улсын гэрээг соёрхон баталсан байдаг.

Тэдгээрээс хүний эрхийн суурь **8** конвенц, тэдгээрийг дагалдах **40** гэрээнд нэгдээд байна.

Эдгээр гэрээ, пакт болон Нэгдсэн Үндэстний Байгууллага, олон улсын байгууллагын өмнө хүлээсэн үүргээ Монгол Улс биелүүлэхийн төлөө байнгын хүч чармайлт тавьж, тайлан илтгэлүүдээ хүргүүлж, дүгнэлт, зөвлөмжийг хэрэгжүүлж байна.

Тиймээс Монгол Улсын Их Хурал Хүний эрхийн түгээмэл тунхаглал батлагдсаны 75 жилийн болон бусад түүхэн ойнуудад зориулан Хүндэтгэлийн хуралдаан зарлан хуралдуулж байна.

Тунхаглал нь зөвлөмжийн шинжтэй баримт бичиг боловч хүний эрхийн талаарх олон улсын гэрээ, улс орнуудын Үндсэн хууль, хууль тогтоомжийн үндэс болсоор ирсэн. Энэ утгаараа Тунхаглалын үзэл санаа 1992 онд баталсан Монгол Улсын ардчилсан, шинэ Үндсэн хуульд бүрэн тусгалаа олж, хүний салшгүй эрхийг анх удаа бүрэн цогцоор нь баталгаажуулсан.

Үндсэн хуулийн бусад заалтууд Нэгдүгээр бүлэг бол үндсэндээ Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал. Хоёрдугаар бүлэг бол **18** зүйлээр хүний эрх, **60** язгуур салшгүй эрхийг баталгаажуулсан.

Энэ эрхүүдийг хангахын төлөө Гурав, Дөрөв дэх бүлгүүд. Одоо өөрөөр хэлбэл Улсын Их Хурал, Засгийн газар, Ерөнхийлөгч, шүүх эрх мэдэл бол бие

биендээ хяналт тавьж монгол хүний эрхийг хангахын төлөө л одоо энэ Үндсэн хуулийн мөн чанар оршиж байдаг нь энэ ардчилсан Үндсэн хуулийн уг үндэс нь юм гэж хэлж болно.

Ийм учраас Монгол Улсын шинэ Үндсэн хууль бол Монгол Улсын бүрэн эрхт байдал гэсэн Нэгдүгээр бүлгээр эхэлж Хүний эрх, эрх чөлөө гэсэн Хоёрдугаар бүлгийн 16 дугаар зүйлд Монгол Улсын иргэний эдлэх эрх, үндсэн эрх чөлөөг **18** бүлэг заалт, **60** гаруй эрхээр баталгаажуулсан юм. /алга ташив/

Ингэснээрээ Гурав, Дөрөв дэх бүлэг төрийн байгууллагын бүтэц, тогтолцоо, засаглалын эрх, үүрэг нь гагцхүү хүний эрх, эрх чөлөөг хангахад чиглэнэ гэсэн үзэл баримтлалыг дэвшүүлсэн.

Үндсэн хуулийнхаа энэхүү үзэл баримтлалд тулгуурлан Монгол Улсын Их Хурлаас “Монгол Улсын Их Хурлын 2019-2024 онд хэрэгжүүлэх стратеги төлөвлөгөө”-г баталсан.

Энэхүү төлөвлөгөөндөө “ард түмний засаглах эрхийг хангаж, хүний эрх, эрх чөлөөг дээдлэх” нь эрхэм зорилго мөн хэмээн парламентын эрхэм зорилгыг тодорхойлсон.

Энэ зорилгоо хэрэгжүүлэхийн тулд Монгол Улсын Их Хурлаас “Гурван D” буюу гурван хэмжээст, зөвхөн босоо биш хэвтээ хариуцлагын тогтолцоог бий болгох.

“Гурван D” буюу

- **Digital,**
- **Democratic,**
- **Deliberative** парламент болох

- **Цахим,**
- **Ардчилсан,**
- **Зөвлөлддөг** ард иргэдийн оролцоотой ийм парламент болох парламентын шинэчлэлийн зорилтыг дэвшүүлэн ажиллаж байна.

Энэ хүрээнд хууль тогтоомжийн төсөлд хүний эрхийн талаас нь үнэлгээ хийдэг аргачлалыг хэвшүүлж, **“ХҮНИЙ ЭРХИЙГ ДЭЭДЛЭГЧ”** парламент байхаа зарласан.

Улсын Их Хурал, Олон Улсын Парламентын Холбоотой хамтран Хүний эрх, жендэрийн асуудлаарх парламентын өөрийн үнэлгээг өнгөрсөн сард хийлээ.

Олон Улсын Парламентын Холбооноос энэ арга хэмжээг зохион байгуулахдаа Монгол Улсыг хүний эрхийн өөрийн үнэлгээг Олон Улсын Парламентын Холбооноос баталсан аргачлалын дагуу анх удаа хийсэн парламент нь Монгол Улсын Их Хурал боллоо гэдгийг мэдэгдсэн.

Цахим шилжилтийн хүрээнд бид **“D-parliament”**, **“D-petition”** программуудыг нэвтрүүлж, ард түмний засаглах эрхийг хангаж, парламентын ардчиллыг төлөвшүүлж байна.

Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороо Ажлын хэсэг байгуулж, олон улсын гэрээний хэрэгжилтийн тайланг Нэгдсэн Үндэстний Байгууллагын Гэрээний хороонд хүргүүлж буй байдал, Гэрээний хорооноос ирүүлсэн зөвлөмжийн хэрэгжилтэд үнэлэлт дүгнэлт өгөх, санал дүгнэлт боловсруулахаар ажиллаж байна.

Монгол Улс хүний эрхийн төлөв байдлын талаарх үндэсний

- Анхдугаар илтгэлээ **2010 онд,**
- Хоёрдугаар илтгэлээ **2015 онд,**
- Гуравдугаар илтгэлээ **2021 онд**

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүний эрхийн зөвлөлөөр хэлэлцүүлээ.

Гурав дахь илтгэлийг хэлэлцээд тус Зөвлөлөөс ирүүлсэн **190** зөвлөмжийг 2023-2025 онд хэрэгжүүлэх ерөнхий төлөвлөгөөг Монгол Улсын Засгийн газар батлан хэрэгжүүлж байна.

Хүний эрхийг хамгаалах тогтолцооны асуудлыг авч үзэхдээ хэн зөрчих боломжтой вэ гэдгийг анхаарч үзэх ёстой. Тэгвэл хүний эрхийг зөрчих, хязгаарлах гол субъект нь Төр өөрөө байдаг байна.

Тиймээс төрийн эрх мэдлийг хуваарилах, хуулийн засаглалыг бэхжүүлэхэд онцгой ач холбогдол өгч байна.

Францын агуу сэтгэгч **Шарль де Монтескье** "Хэрэв хууль тогтоох, гүйцэтгэх эрх мэдлийг нэг гарт төвлөрүүлбэл эрх чөлөө хэрэгжихгүй. Шүүх эрх мэдэл нь хууль тогтоох, гүйцэтгэх эрх мэдлээс тусгаарлагдаагүй тохиолдолд эрх чөлөө үл ориино. Хэрэв шүүх эрх мэдэл хууль тогтоох эрх мэдэлтэй нэгдвэл иргэдийн амьдрал, эрх чөлөө дур зоргын золиос болно.

Шүүх эрх мэдлийг гүйцэтгэх эрх мэдэлтэй нэгтгэвэл шүүгчид дарангуйлагчид болох үүд хаалга нээгдэнэ" гэсэн билээ.

Тиймээс засаглалын харилцан хяналт-гэнцлийг хангах чиглэлээр 2019,

2023 онд Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулаад байна.

Төр бол ердөө л хүний эрхийг хангах тогтолцоо юм. Төр гагцхүү хуулиар зөвшөөрсөн хүрээнд ажиллаж, шийдвэр гаргах үүрэгтэй. Харин иргэн хуулиар хориглоогүйг хийх эрхтэй гэдгийг бид ямагт санаж байх учиртай.

Хүн бүхэнд амьдралын зорилго, хүсэл мөрөөдөл байдаг.

Зорилгодоо хүрэхийн тулд авьяас чадвараа нээн хөгжүүлэх, мэдлэг боловсрол эзэмших, хөдөлмөрлөх, өмч эзэмших, баялаг хуримтлуулах, айдас хүйдэсгүй амьдрах гээд хүний жам ёсны эрхийг эдлэх бүхий л нөхцөлөөр хангагдах ёстой.

Энэ үүднээс Улсын Их Хурал хүний эрхийг хамгаалах тогтолцоог эрх зүйн шинэчлэлээр дэмжих чухал алхмууд хийсэн. Тухайлбал,

Нэгдүгээрт, “Хүний эрхийн үндэсний байгууллагуудын Парисын зарчим”-д нийцүүлэн Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2020 онд баталсан.

Хоёрдугаарт, Монгол Улсад анх удаа нээлттэй, ил тод сонгон шалгаруулалтаар Комиссын гишүүдийг томилж, хараат бус, бие даасан байдлаар ажиллах боломжийг бүрдүүлсэн.

Өмнө нь улс төрийн томилгоогоор томилдог байсан энэ томилгоог нээлттэй сонсголоор ард иргэдээс сонгон шалгаруулж томилдог болсон.

Гуравдугаарт, Комисс үйл ажиллагаагаа хараат бусаар

хэрэгжүүлэхэд шаардлагатай төсвийн хэмжээг 2021 оныхоос жил бүр нэмэгдүүлснээр үндсэндээ 4 дахин нэмэгдүүллээ.

Дөрөвдүгээрт, Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх илтгэлийг зөвхөн Байнгын хороогоор хэлэлцдэг байсан уламжлалыг өөрчилж, 2020 оноос эхлэн Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцдэг болж, Улсын Их Хурлын 3 тогтоол гаргаад байна.

Тавдугаарт, Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуулийг 2021 онд баталсан.

Ингэснээрээ бид Ази тивдээ хүний эрх хамгаалагчийг хамгаалах тогтолцоо бий болгосон анхны улс боллоо.

Үүнийг маань Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүний эрхийн Дээд комиссарын алба онцлон сайшаасан. “Эмнести интернэшнл” байгууллагаас энэхүү Хүндэтгэлийн хуралдаанд ирүүлсэн мэндчилгээндээ мөн баяр хүргэж, онцлон тэмдэглэсэн байна.

Зургадугаарт, Улсын Их Хурлын тогтоолоор Комиссын Хүний эрх хамгаалагчийн болон Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүдийг томилсноор Хүний эрхийн Үндэсний Комиссын дэргэд хараат бус, Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх механизм, Хүний эрх хамгаалагчийн хороо байгуулагдлаа.

Долдугаарт, Монгол Улсын Шүүхийн тухай, Хууль зүйн тусалцааны тухай хуулиудыг шинэчлэн баталлаа.

Иргэний мэдээлэл хайх, хүлээн авах эрхийг хангах зорилгоор Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай, хүний хувийн мэдээллийг ашиглах, аюулгүй байдлыг хангах харилцааг зохицуулсан Хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийг баталсан.

Наймдугаарт, Төр, хувийн хэвшлийн аль алинд хүний эрх, эрх чөлөөг зөрчиж, улсын болон иргэний боломжийг хулгайлж буй хорт үзэгдэл бол авлига хэмээн үзэж, авлигыг хүний эрхийн зөрчил гэж тодорхойлж Авлигын эсрэг чуулганыг зарласан.

Улсын Их Хурал **2023** оны хаврын чуулганаа **“АВЛИГЫН ЭСРЭГ ЧУУЛГАН”** болгохоо зарлаж, **“АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР”**-ийг шинэчлэн баталсан.

Түүнчлэн Эрүүгийн болон Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулж, төрийн өндөр албан тушаалтнууд гэмт хэрэгт холбогдвол хөөн хэлэлцэх хугацааг зогсоох, авлига, албан тушаалын гэмт хэрэгт оногдуулах ялын бодлогыг чангатгах, өршөөл, уучлал үзүүлэхгүй байх, хялбаршуулсан журмаар шийдвэрлэдэггүй байх зэрэг зохицуулалтыг тусгалаа.

Есдүгээрт, Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийг шинэчилж, нэр дэвшигчдийн 30-аас доошгүй хувь нь аль нэг хүйсийнх байх зохицуулалтыг 2024 оноос, 40-өөс доошгүй хувь байхыг 2028 оноос мөрдөхөөр болж жендэрийн эрх тэгш байдлыг хангахад чиглэсэн дэвшил гаргалаа. /алга ташив/

Мөн нам, эвслээс жагсаалтаар нэр дэвшигчдийн хүйсийн харьцаа **1:1**

байхаар Сонгуулийн хуульд тусгаж зохицуулалтыг хийлээ.

Хүний эрхийг хамгаалах эдгээр хүч чармайлтыг дэмжиж, хамтран ажиллаж, сайн үйлсийг түгээж яваа хүний эрхийг хамгаалагч байгууллага, хүмүүс манайд цөөнгүй бий.

Тухайлбал, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг олон нийтэд таниулж, хамгаалах үйлсэд үнэтэй хувь нэмэр оруулсан Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны ажилтан **БУЯНЖАРГАЛЫН БОЛООРОО-г Европын Холбооноос “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн төлөө тэмцэгч”**-ээр өргөмжилсөн. /алга ташив/

Мөн Төв Азийн эдийн засгийн хамтын ажиллагааны хөтөлбөрөөс жендэрийн тэгш байдлыг бэхжүүлэхэд оруулсан хувь нэмрийг нь өндрөөр үнэлж, Монгол Улсын Хүчирхийллийн эсрэг үндэсний төвийг шилдгээр шалгаруулсан байна. /алга ташив/

Эдгээр хүмүүс, байгууллагын төлөөлөл өнөөдрийн хуралдаанд хүндэт зочноор оролцож байгаа.

Та бүхэнд болон хүний эрхийг хамгаалагч, тэмцэгч бүх хүмүүст баяр хүргэе. /алга ташив/

Эрхэм гишүүд ээ,

Манай улсад хүний эрх зөрчигдөх явдал арилаагүй, гарсаар байна. Нэгдсэн Үндэстний Байгууллагын хүний эрхийн механизмуудаас гаргаж буй удаа дараагийн дүгнэлт, зөвлөмжүүдэд ч энэ талаар дурдсаар байгаа.

Хот, хөдөөгийн нийтлэг асуудал болсон агаар, орчны бохирдол, авто

замын түгжрэл нь хүний амьд явах эрхэд ноцтой заналхийлэл учруулж байна.

Ийм учраас **“Хот, хөдөөгийн сэргэлт”**-ийн бодлогыг Засгийн газар дэвшүүлж, бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалыг хэрэгжүүлэхээр төлөвлөж, хот, хөдөөд төвлөрлийг сааруулж, хүний эрхийг хангахад чиглэсэн өөрчлөлтүүдийг санаачилж байгааг энэ бол хүний эрхийн төлөө хийж байгаа чухал санаачилга гэж үзэж байна.

Мөн хувийн өмч бол хүн эрх, эрх чөлөөтэй байх, түүнийгээ бодитоор эдлэх гол нөхцөл мөн.

Гэтэл хувийн өмчийг хамгаалах баталгааг зөрчих явдал гарсаар байна. Хувийн өмч гэдэгт гадаадын хөрөнгө оруулагчийн эрх ашгийг хамгаалах асуудал ч мөн хамаарна гэдгийг онцлон тэмдэглэе.

Гадаад, дотоодын гэлтгүй хөрөнгө оруулсан энэ хувь, хувьсгалын хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах асуудлыг хүний эрхийн хүрээнд онцгойлон авч үзэх ёстой.

Авлигын сүлжээ илчлэгдэж, баялгийн хуваарилалт, орлогын тэгш бус байдал нийгэмд бухимдал үүсгэж, энэ хэрээр хүний эрхийн зөрчил нэмэгдэх хандлагатай болсон.

Өмгөөлөл, хууль зүйн туслалцаа авах иргэний эрх бүрэн хангагдахгүй, эрүү шүүлт тулгаж, хүнлэг бусаар доромжлон харилцаж, хууль бусаар мөрдөх ажиллагаа явуулж, ял шийтгэсэн баримт олон нийтэд дэлгэгдэж байсан.

Гэхдээ энэ сүүдэр одоо хүртэл бүрэн арилаагүй байна гэж үзэж болно.

Хүүхэд, эмэгтэйчүүдийг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хамгаалах хууль тогтоомж шинэчлэгдсээр байгаа боловч хэрэг зөрчил буурахгүй, хүнлэг бус, ёс бус үйлдэл, доромжлол үйлдэгдсээр байгааг нийгмээрээ бухимдан шүүмжилж байна.

Олон нийтийн цахим мэдээллийн сүлжээ хурдацтай хөгжиж, тэндээс иргэд мэдээлэл олж авахын зэрэгцээ, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх боломжууд нэмэгдсэн.

Гэсэн хэдий ч хиймэл оюун ухаан, цахим орчинд хүний эрх, аюулгүй байдлыг хангах асуудал тулгамдаж байна.

Хотын алслагдсан хороололд амьдардаг иргэд, хөдөөгийн малчин өрхүүдийн хувьд интернэтийн хурд, сүлжээний хүртээмж хангалтгүй байна.

Өндөр настан, үндэстний цөөнх, хөгжлийн бэрхшээлтэй иргэд цахим үйлчилгээг тэр бүр авч чадахгүй байгаа нь судалгаагаар тогтоогдсон. Энэ нь нийгэмд цахим хуваагдлыг бий болгож байна.

Дэлхийн улс орнууд хиймэл оюун ухааны чатбот технологийн программуудыг ашиглаж худал, захиалгат мэдээлэл тараах, хүний эрх, нэр төрд халдах байдалд тодорхой цензур тогтоохыг эрмэлзэж байгаа ч бүрэн хяналт тавьж чадахгүй байна.

Үүнтэй холбогдуулан Америкийн Нэгдсэн Улс болон Европын 40 гаруй оронд өндөр хандалттай зарим вэбсайтын үйл ажиллагааг хязгаарлахад хүрсэн байна.

Энэ ташрамд хүний эрхийг хуулиар хязгаарлаж болох боловч тэр нь зөвхөн бусдын эрх, нэр төрийг хүндэтгэх, үндэсний аюулгүй байдал, нийгмийн дэг журам, хүн амын эрүүл мэнд, ёс суртахууныг хамгаалах зайлшгүй шаардлагаар л хийгддэг болохыг анхааруулж байна.

Аливаа хэлмэгдүүлэлтээс хүн бүр ангид байх ёстой. Үүний нөгөө талд ял завших байдал хэрхэвч байж болохгүй.

Ийм учраас хүн биш хууль засагладаг тогтолцоог л бид бүрдүүлэх нь энэ парламентын үндсэн зарчим мөн.

Та бүхэнд **The World Justice Project**-ээс дэлхийн улс орнууд хууль дээдлэх зарчмыг буюу **rule of law** гэж байгаа.

Хууль дээдлэх ёсыг хэрхэн хангаж буй талаар гаргадаг индексээр Монгол Улс хаахна явааг 2017 болон 2023 оноор харьцуулан дэлгэцээр үзүүлье. Тухайлбал,

▪ **Хүний үндсэн эрхийн үзүүлэлтээр:**

2017 онд 113 орноос **56-д** орж байсан бол **2023 онд** 142 орноос **69-д**;

▪ **Авлигын үзүүлэлтээр:**

2017 онд 113 орноос **70-д** орж байсан бол **2023 онд** 142 орноос **86-д**;

▪ **Эрүүгийн эрх зүйн хэрэгжилтээр:**

2017 онд 113 орноос **50-д** орж байсан бол **2023 онд** 142 орноос **66-д**;

▪ **Нээлттэй засаглалын байдлаар:**

2017 онд 113 орноос **61-д** жагсаж байсан бол **2023 онд** 142 орноос **74-д** жагсаж байна.

Эндээс бид чухам ямар асуудалд илүү анхаарах ёстой вэ гэдэгт дүгнэлт хийх ёстой.

Эрх зүйн онолч, сэтгэгч **Жон Локк** /John Locke/ “Хүн бүр өөрийн шинж чанараар эрх чөлөөтэй бөгөөд тухайн хүн өөрөө л зөвшөөрөөгүй тохиолдолд түүнийг өөр хэн ч, юу ч энэ газар дээрх аливаа эрх мэдлийн захиргаанд оруулж чадахгүй” гэжээ.

Мөн “Хуулийн зорилго бол эрх чөлөөг устгах буюу хавчин гадуурхах явдал биш, харин түүнийг хамгаалж, өргөжүүлэх явдал мөн” гэсэн байдаг.

Тиймээс Монгол Улс хүн засагладаг биш, хууль засагладаг, хууль нь хүний эрх, эрх чөлөөг тууштай хамгаалдаг, хангадаг тогтолцоо бүрдүүлэхийг эрхэм зорилгоо болгож байна.

Хууль дээдэлдэг, хууль нэг мөр үйлчилдэг нийгэмд л хүн эрх чөлөөтэй амьдардаг.

Тиймээс эрх чөлөөнийхөө эзэн байх эрхийг иргэддээ эдлүүлэх үүрэг, хариуцлага Монгол төрийнх юм. Хүний эрх бол төрийн аливаа байгууллага, тэнд алба хаагчдын заавал эзэмшсэн байх соёл мөн гэдгийг онцлон тэмдэглэе.

Эрхэм гишүүд ээ,

Монгол Улс Хүний эрхийн түгээмэл тунхаглалын үзэл санаанд үнэнч байж, тууштай сахисаар ирсэн, цаашид ч хэлбэрэлтгүй мөрдөж, хүний эрхийг хамгаалах дэлхий нийтийн үйлсэд хувь нэмрээ оруулах эрмэлзэл төгс байгаагаа нотолж;

Монгол Улсын Их Хурлын хүндэтгэлийн хуралдааны энэхүү индрээс:

1.Гөрөөс хүний эрхэнд халдах ямар нэгэн боломж, нөхцөл үүсгэхээс байнга сэргийлж, хүний эрх, эрх чөлөөг хамгаалахад нэн чухал хууль тогтоомжуудыг баталж, хэрэгжилтэд нь хяналт тавих;

2.Хүний эрхийн конвенц, гэрээ, пактуудаар хүлээсэн үүргээ биелүүлж, Хүний эрхийн төлөв байдлын талаар Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүний эрхийн хороо, бүтцийн бусад байгууллагуудад тайлагнах механизм бүрдүүлж, парламентаас манлайлж ажиллах;

3.Гэрээ, конвенцуудад дотоодын хууль тогтоомжийг нийцүүлэх, олон улсын гэрээний заалтыг шүүн таслах үйл ажиллагаанд хэрэглэх нөхцөлийг бүрдүүлэх, олон улсын гэрээний үүрэг, зөвлөмжийн биелэлтийн явцыг Улсын Их Хуралд тогтмол тайлагнадаг журамд шилжиж, нээлттэй сонсголоор хянан хэлэлцэх;

4.Хүний эрхийн боловсролыг иргэд, хүүхэд залууст олгох, тэдэнд зориулсан сурах бичиг хэвлэх, эрх эдлэгч, үүрэг хүлээгчийг чадавхжуулах сургалт зохион байгуулах, мэдлэгжүүлэх, чадавхжуулах, төрийн албан хаагчдад зориулан хүний эрхийн гарын авлага гаргах, тэдний хүний эрхийн мэдлэг, мэдрэмжийг шалган аттестатчилах эрх зүйн зохицуулалт бий болгох;

5.Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблейгаас гаргасан тогтоолын хүрээнд Ахмадын эрхийн асуудлаар тусгайлсан эрхийн

баримт бичиг боловсруулан батлах санаачилгыг дэмжиж, уг санаачилгад нэгдэх;

6.“Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөр-2”-ыг батлан хэрэгжүүлэх;

7.2025 онд болох Нэгдсэн Үндэстний Байгууллагын 80 жилийн ойг угтаж, 2025 оныг Нэгдсэн Үндэстний Байгууллагын дүрмийн жил болгох;

8.Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүний эрхийн мэдлэг олгох, сургах, чадавхжуулах Ази, Номхон далайн бүсийн төвийг Монгол Улсад байгуулах.

Ийм **8** санаачилгыг дэвшүүлж байгааг Улсын Их Хурал, Засгийн газрын эрхэм гишүүд Та бүхэн дэмжиж, ажил хэрэг болгохыг уриалж байна.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

Монгол Улсын нийт иргэд, Улсын Их Хурал, Засгийн газрын эрхэм гишүүд, Хүндэт зочид Та бүхэндээ маргааш тохиох Олон улсын Хүний эрхийн өдрийн мэндчилгээ дэвшүүлж, хамгийн сайн сайхныг хүсэн ерөөе. /алга ташив/

Одоо Хүний эрхийн түгээмэл тунхаглал батлагдсаны 75 жилийн ойд зориулсан Улсын Их Хурлын хүндэтгэлийн хуралдаантай холбогдуулан Европын Аюулгүй Байдал, Хамтын Ажиллагааны Байгууллагын Парламентын Ассамблейн Ерөнхийлөгч, хатагтай Пиа Каума /Pia Liisa Kauma/-гаас мэндчилгээ, захидал ирүүлсэн байна.

Хатагтай Пиа Каума танд талархал илэрхийлье.

Энэ хооронд Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүний эрхийн дээд комиссар, ноён Фолькер Тюрк /Volker Türk/ цахимаар мэндчилгээ дэвшүүлснийг одоо үзүүлье.

Фолькер Тюрк: Эрхэм Улсын Их Хурлын гишүүд ээ,

Одоогоос 75 жилийн өмнө дэлхийн хоёр дайн, геноцид, цөмийн аюул, их хямралд нэрвэгдсэн улс орнууд Хүний эрхийн түгээмэл тунхаглалыг хамтдаа баталж, хүн бүрийн эрхийг хамгаалж, баталгаажуулах үүрэг хүлээсэн.

Хүйтэн дайн намжиж, дэлхийг хамарсан цахим сүлжээ тэлэх шинэ эрин цагт дэлхийн ертөнц дахин нэгдэн 1993 онд Венийн тунхаглал, үйл ажиллагааны хөтөлбөрийг баталсан билээ.

Энэхүү түүхэн хоёр үйл явдлыг бид энэ жил тэмдэглэж байгаа нь өндөр ач холбогдолтой юм.

Хүний эрхийн түгээмэл тунхаглал нь улс төр, эдийн засаг, нийгэм, соёл, иргэний гээд бүхий л эрхийг хамарсан орчин цагийн хүний эрхийн дэглэмийн үндсийг тодорхойлсон.

“Венийн тунхаглал”-ын /VIENNA DECLARATION/ үйл ажиллагааны хөтөлбөр нь эдгээр эрх хуваагдашгүй, түгээмэл гэдгийг дахин баталгаажуулж, миний хашиж буй албыг байгуулах суурийг тавьсан.

Эдгээр баримт бичиг нь дэлхий даяар эерэг өөрчлөлтийг бодитоор авчирсан.

Хүний эрхийг баталгаажуулах аливаа хүчин чармайлт нь үр дүнтэй

шийдвэр гаргах сайн засаглалын цөм болсоор байгааг бид тод харж байна.

Хүмүүс эрхээ хамгаалуулах, шударга бус явдлын эсрэг дуу хоолойгоо илэрхийлэх эрх эдлэх болсныг бид **BLACKLIVESMATTER**, **#MeToo**, **FRIDAYS FOR FUTURE** уугуул иргэдийн хөдөлгөөн, эмэгтэйчүүдийн эсэргүүцлийн жагсаал зэрэг хөдөлгөөнөөс харж болно.

Залуус санаа бодлоо илэрхийлэхдээ ихэвчлэн хүний эрхийн хэлээр ярьдаг болсон.

Зарим улс орны шүүхийн байгууллага хүний эрхийг хангах хариуцлага хүлээж, тэр дундаа саяхан хүлээн зөвшөөрөгдсөн эрүүл орчинд амьдрах эрхийг хамгаалах үүргийг хүлээсэн.

Тиймээс парламентын хууль тогтоох, хяналт тавих чиг үүрэг чухал үүрэгтэй.

Мөн тэгш бус байдлыг арилгах, Тогтвортой хөгжлийн зорилтуудыг хэрэгжүүлэх үүднээс хүний эрхэд суурилсан эдийн засаг, үндэсний төсөв гэсэн томъёолол газар авсаар байна.

Хүний эрхийн түгээмэл тунхаглалаас улбаатай энэхүү ахиц дэвшил нь хүний эрх биднийг нэгтгэж, тулгамдаж буй томоохон сорилтыг шийдвэрлэх арга замыг бий болгож буйн нотолгоо юм.

Та бидэнд цаашид хийх зүйл олон байна.

Дэлхий даяар ямар нэгэн шийтгэлгүйгээр хүний эрхийг зөрчих явдал өдөр бүр тохиосоор байна.

Та бид өнөөдөр ердийн юм шиг хүлээн авдаг хүний эрхийн асуудлаар бид шинэлэг бэрхшээлтэй тулгарсаар байна. Тухайлбал, жендэрийн эрх, уур амьсгалын өөрчлөлт, зэвсэгт мөргөлдөөн, бусдыг үзэн ядсан яриа, иргэний нийгмийн орон зай хумигдах явдал, шинэ технологи тэр дундаа хиймэл оюун ухаан зэрэг сорилтыг даван туулахад хүний эрхэд суурилсан хариу арга хэмжээ авах шаардлагатай.

Эрхэм гишүүд ээ,

Эрхэм оролцогчид оо,

Хүний эрхийн тэмдэглэлт энэ ойн хүрээнд өнөөдрийн Та бүхний хуралдуулж буй чуулган шиг үндэсний яриа хэлцэл, арга хэмжээ чухал ач холбогдолтой.

Монгол Улс өнгөрсөн жилүүдэд хүний эрхийг хангах чиглэлээр томоохон ахиц гаргасан.

Энэ ололт амжилтад хүрэхэд Улсын Их Хурал чухал үүрэг гүйцэтгэж ирсэн. Тухайлбал,

- **2000 онд** Хүний эрхийн Үндэсний Комисс байгуулах,
- **2003 онд** Хүний эрхийн үндэсний үйл ажиллагааны хөтөлбөрийг батлах,
- **2016 онд** Цаазаар авах ялыг халах,
- **2021 онд** Ази, Номхон далайн бүс нутгийн хэмжээнд Хүний эрхийг хамгаалагчдын тухай анхны хуулийг батлахад

Улсын Их Хурал шийдвэрлэх үүрэгтэй байсан.

Мэдээж хийх ажил үргэлж байдаг. Хүний эрх бол эцэс төгсгөлгүй замнал юм.

Миний ахалж байгаа оффис болон танай улсад байгаа Нэгдсэн Үндэстний Байгууллагын төлөөлөгчийн газар Та бүхний хүчин чармайлтыг дэмжихээр энд байна.

Мөн Монгол Улс бүс нутаг болон олон улсад манлайлах үүрэг гүйцэтгэх боломжтой.

Хүний эрхийн түгээмэл тунхаглал батлагдсаны 75 жилийн ойг тохиолдуулан Монгол Улсын Их Хурал хүндэтгэлийн чуулганыг зарлан хуралдуулж байгаад талархаж байна.

Өнөөдрийн хурлын үр дүнг удахгүй ажилтнуудаасаа сонсоно гэдэгтээ итгэлтэй байна.

Мөн Даваа гарагт Женевт болох “Хүний эрхийн 75” дээд түвшний арга хэмжээний үеэр танай улсын амлалтыг хүлээн авч танилцахдаа таатай байх болно.

Эрх чөлөөг бүрэн хангаснаар хүмүүсийн амьдралд болон дэлхийд бүхэлд нь тайван, тогтвортой ирээдүйг бий болгоно.

Хэрэв бид хүний эрхийн нийтлэг хэллэг, бүгдэд зориулсан эрх чөлөө, тэгш байдал, шударга ёсны тухай амлалтуудыг удирдлагаа болговол хүршгүй мэт санагдах зүйлд ч хүрч болно гэдэгт итгэлтэй байна.

Баярлалаа. /алга ташив/

Г.Занданшатар: Мэндчилгээ дэвшүүлсэн Нэгдсэн Үндэстний

Байгууллагын Хүний эрхийн дээд комиссар Фолькер Тюрк танд талархал илэрхийлье.

Мэндчилгээнүүдийг орчуулж англи, монголоор Улсын Их Хурлын гишүүдэд болон хүндэт зочдод тараасан байгаа гэдгийг бас мэдэгдье.

Одоо Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий ассамблейн 78 дугаар чуулганы дарга, ноён Деннис Франсис /Dennis Francis/ цахимаар мэндчилгээ дэвшүүлнэ.

Д.Франсис: Эрхэм хүндэт Монгол Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар,

Эрхэм хүндэт Улсын Их Хурлын гишүүд,

Эрхэм зочид, хатагтай ноёд оо!

Хүний эрхийн түгээмэл тунхаглал батлагдсаны 75 жилийн ойг тохиолдуулан Та бүхэнд хандан үг хэлэх завшаан тохиолдсонд баяртай байна.

Орчин цагийн түүхэнд хамгийн их орчуулагдсан баримт бичиг болох энэхүү тунхаглалд тусгасан тусгасан агуулга бол бидний хийж буй бүх зүйлийн үндэс суурь юм.

Энэ нь “Хүн бүр төрөхөөсөө эрх чөлөөтэй, нэр төр, эрхийнхээ хувьд адил тэгш байна” гэсэн заалтаар тодорхой илэрхийлэгдэх болов уу.

Энэ бол газар сайгүй хүн бүрийн эдлэх хүний эрхийн суурь зарчмууд түгээмэл, салшгүй, хуваагдашгүй, харилцан хамааралтай, харилцан уялдаатай байдлыг баттай нотолдог билээ.

Бид энэхүү чухал Тунхаглалын 75 жилийн ойг тэмдэглэж байгаа ч Тунхаглалаар тогтоосон хэм хэмжээ биелээгүй байгаа нь гашуун үнэн гэдгийг хүлээн зөвшөөрөх учиртай.

Дэлхий даяар сая сая хүн зовж шаналж, наад захын эрхээ ч эдэлж чадахгүй байсаар байна.

Үүнийг 2030 он хүртэлх Тогтвортой хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд тулгарч буй сорилт бэрхшээл, дэлхий даяар улам бүр газар авсаар байгаа зөрчил, мөргөлдөөнөөс бид илхэн харж байна.

Эдгээр зорилтын хэрэгжилт удааширч, орхигдсоор байгаа нь Та бидний өөрсдийн үйл ажиллагаатай ч зарим тохиолдолд холбоотой.

Уур амьсгалын өөрчлөлт болон үр дагаврыг шийдвэрлэх амлалт болон хүчин чармайлт хангалтгүй байна.

Маргааныг дайн, мөргөлдөөний замаар шийдвэрлэх гэсэн оролдлого нэмэгдсээр байна.

Ядуурлаас үүдэлтэй нийгмийн тэгш бус байдал даамжирсаар байна. Энэ бүхнийг засахын тулд бид илүү ихийг хийж чадна, хийх ч ёстой.

Хүний эрхийн түгээмэл тунхаглал бол Та бидний Алтангадас юм.

Энэхүү баримт бичигт тулгуурлаж бид Тогтвортой Хөгжлийн Зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагааг түргэтгэх, энх тайван, хөгжил дэвшил, хөгжил цэцэглэлт, тогтвортой байдалд хүргэх зорилгоор **“2024 оны Ирээдүйн төлөө дээд хэмжээний уулзалт”**

/2024 Summit for the Future/ зэрэг арга хэмжээг зохион байгуулах болно.

Энэ бүх чиглэлээр бид үр дүн гаргах үүднээс бүх түвшинд, бүх салбарт хамтран ажиллах болно.

Үүнийг хийхэд Улсын Их Хурал болон дэлхийн нийт парламентын үүрэг зайлшгүй чухал. Олон талт хэлэлцээрүүд нь улс орон, нийгэм дэх хүмүүсийн амьдралыг бодитоор өөрчлөх ажил болж өрнөдгийг Парламент бүр ойлгож, дэмжиж ажилладаг.

Энэ орон зайд л бид иргэний болон улс төрийн эрх, эдийн засаг, нийгэм, соёлын эрх, түүнчлэн хөгжих эрхийг хангаж чадна.

Та бүхний хууль тогтоох, хянах, төсөв батлах эрх мэдэл нь хүний эрхийг хамгаалах гол арга хэрэгсэл юм.

Энэ завшааныг ашиглан ардчилсан засаглалыг бэхжүүлэх, ядуурлыг арилгахад чиглэсэн “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг баталсныг сайшаан тэмдэглэж буйг минь хүлээн авна уу.

Улсын Их Хурлын эрхэм дарга аа,

Хүний эрхийн түгээмэл тунхаглал нь хүн төрөлхтний сайн сайхан ирээдүй рүү чиглүүлэх гэрэл, хөтлөх зам билээ.

Даян дэлхийн шударга ёсны төлөөх хүн төрөлхтний хамгийн ариун нандин тангаргийг сахиж, бамбараа бадраан манлайлах тууштай зүтгэлд тань би итгэл дүүрэн байна.

Та бүхэнд баярлалаа. /алга ташив/

Г.Занданшатар: Баярлалаа. Мэндчилгээ дэвшүүлсэн Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий ассамблейн 78 чуулганы дарга, ноён Деннис Франсис танд талархал илэрхийлье.

Одоо Монгол Улс дахь Нэгдсэн Үндэстний Байгууллагын суурин зохицуулагч, ноён Тапан Мишра /Tapan Mishra/ цахимаар мэндчилгээ дэвшүүлнэ.

Т.Мишра: Эрхэм хүндэт Улсын Их Хурлын дарга Гомбожавын Занданшатар танаа,

Эрхэм хүндэт Улсын Их Хурлын гишүүд ээ,

Эрхэмсэг зочид, хатагтай, ноёд оо,

Хүний эрхийн түгээмэл тунхаглал батлагдсаны 75 жилийн ойн баярт зориулсан Улсын Их Хурлын хүндэтгэлийн хуралдаанд үг хэлэх завшаан тохиосон нь миний хувьд нэр төрийн хэрэг билээ.

Хүний эрхийн түгээмэл тунхаглал гэх энэхүү түүхэн баримт бичиг нь яс үндэс, шашин шүтлэг, жендэр болон өөр бусад ялгаатай байдлаас үл хамаарах хүн нэг бүрийн язгуур үнэ цэн, тэгш эрхийг тунхагласан юм.

Тус баримт бичиг нь дэлхийн бүх ард түмэн, улс орны хэрэгжүүлбэл зохих нийтлэг хэм хэмжээг тодорхойлж, эрх чөлөө, шударга ёс, ардчиллын төлөөх дэлхийг хамарсан хөдөлгөөний эх үндэс нь болсон юм.

Энэхүү түүхэн ойг тэмдэглэж буй энэ цаг үед бид хүний эрхийг хамгаалахад урьд хожид тохиож

байгаагүй томоохон сорилтууд төдийгүй шинэ боломжуудтай тулгарч байна.

Авлига, уур амьсгалын хямрал, дижитал шилжилт, популизм болон экстремизм газар авч буй нь бидний хүсэл зориг болоод эв нэгдлийг сорьж байна.

Үүнтэй зэрэгцээд энэ бүх сорилт бидэнд хамтын ажиллагаа, шинэчлэл, яриа хэлэлцээ, ардчилсан зарчмуудыг бэхжүүлж, тэгш хамруулалт, ялгаатай байдлыг хөхиүлэн дэмжих шинэ боломжуудыг нээж өгч байна.

Ийм учраас Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ, өнгөрсөн үеийн ололт амжилтыг тэмдэглэхийн сацуу хэтийг харж, ирээдүйгээ тодорхойлье!

Хүний эрх, эрх чөлөөг сахин хамгаалах парламентын хяналтыг сайжруулж, бүх хууль тогтоомжийг Хүний эрхийн түгээмэл тунхаглалын зарчмууд болон олон улсын хүний эрхийн хэм хэмжээтэй нийцүүлэх нь нэн чухал.

Бид мөн хүний эрхийн асуудлаар Улсын Их Хурлын ажлын хэсэг байгуулах, тогтоолууд батлах, хүний эрхэд суурилсан хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх зэрэг хүний эрхийн төлөө шинэ санаачилгуудыг хөхиүлэн дэмжих нь зүйтэй!

Иймд Монгол Улсад хүний эрхийг хамгаалан тэмцэхэд хууль тогтоох байгууллагын үүрэг хэзээ хэзээнээс илүү чухал болсон байна.

Хүний эрхийг хамгаалж, холбиrolгүй хэрэгжүүлэх хууль тогтоомжуудыг батлах, Засгийн газраас хүний эрхийг хангах үүрэгтэй нь

уялдуулж эргэж хариуцлага нэхэх, төрийн бодлого болон төсвийн төлөвлөлтийг хүний эрхийн зарчмууд болон хэм хэмжээтэй уялдуулах, мөн нийгмийн бүх төлөөлөл, ялангуяа хамгийн их орхигдсон бөгөөд эмзэг бүлгийнхны дуу хоолой, ашиг сонирхлыг төлөөлөх эрх мэдэл болоод хариуцлага парламентын гишүүд Та бүхэнд бий.

Хүний эрхийг хангах талаарх үйл ажиллагаагаа Тогтвортой Хөгжлийн 2030 хөтөлбөртэй уялдуулж буй Улсын Их Хурлын хүч чармайлтыг миний бие ихэд сайшаан дэмжиж авч байна.

Үүний нэг тод жишээ болох Олон Улсын Парламентын Холбооны дэмжлэгтэйгээр хүний эрх болон жендэрийн тэгш байдлын асуудлаарх өөрийн үнэлгээ хийхийг санаачилсанд баяр хүргэе.

Тус үнэлгээ нь хүний эрхтэй холбогдох ололт амжилт, сорилт бэрхшээл болон тэргүүлэх зорилгоо тодорхойлж, цаашдын үйл ажиллагааны төлөвлөгөөгөө боловсруулахад эерэгээр нөлөөлдөг.

Миний бие мөн Монгол Улсад иргэний болоод улс төрийн эрхийг хамгаалж, ардчиллыг бэхжүүлсэн Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт болон хүний эрхтэй холбогдох шинэ хууль тогтоомжуудыг баталсан явдалд баяр хүргэж байна.

Үүний үр дүнд хараах бус, үр нөлөөтэй хүний эрхийн болон шүүх засаглалын институц бэхжиж буйг дурдахад таатай байна.

Эдгээр нь Та бүхний олон улсын өмнө хүлээсэн хүний эрхтэй холбогдох

үүрэг амлалтаа хүндэтгэн сахих хүчин чармайлтыг тод харуулж байна.

Төгсгөлд нь хэлэхэд, Та бүхнийг хүний эрх, эрх чөлөөг сахин хамгаалах парламентын хяналтыг улам сайжруулахыг уриалж байна.

Засгийн газрын хариуцлагыг дээшлүүлэх, хүний эрхийн зөрчлийг арилгахад Нэгдсэн Үндэстний Байгууллагын хүний эрхийн механизмуудыг хэрэгжүүлэхэд хүч чармайлтаа улам сайжруулахыг хүсье!

Хүний эрхийг хангасан, амар амгалан, тэгш хамруулсан, шударга нийгмийг цогцлооход Та бүхнийг Монгол Улс дахь Нэгдсэн Үндэстний Байгууллагын хамт олон хамтран үр өгөөжтэй түншлэлийг бэхжүүлэхэд хэзээд бэлэн байх болно.

Хатагтай, ноёд оо,

Хүний эрхийн түгээмэл тунхаглал бидэнд “ард түмний хүсэл зориг бол засгийн эрх мэдлийн үндэс байх ёстой” гэдгийг сануулдаг.

Парламентын засаглал бол энэхүү хүсэл зоригийн илэрхийлэл юм. Парламентын засаглал бол ард түмэн, төр хоёрын холбоос юм. Парламентын засаглал бол ардчилал хийгээд хүний эрхийн сахин хамгаалагч юм.

Энэхүү түүхэн үйл явдлыг тохиолдуулан Хүний эрхийн түгээмэл тунхаглалын үнэт зүйлс болон зарчмуудыг хүндэтгэн сахих амлалтаа сэргээн санацгаая.

Хүн бүрд ээлтэй, шударга, тэгш хамруулсан, тогтвортой нийгмийг цогцлоохын төлөө хамтран ажиллацгаая!

Сайн сайхныг хүсье, амжилт хүсье.

Олон улсын хүний эрхийн өдрийн мэндийг хүргэе.

Маш их баярлалаа.

Thank you very much. /алга ташив/

Г.Занданшатар: Мэндчилгээ дэвшүүлсэн Нэгдсэн Үндэстний Байгууллагын суурин төлөөлөгч, ноён Тапан Мишра танд талархал илэрхийлье. /алга ташив/

Одоо “Эмнести Интернэйшнл” олон улсын байгууллагын Ерөнхий нарийн бичгийн дарга, хатагтай Агнес Калламард /Agnès Callamard/ талархлын захидал цахимаар ирүүлснийг Та бүхэнд танилцуулья.

(Хүний эрхийн түгээмэл тунхаглал батлагдсаны 75 жил, Хүний эрх хамгаалагчийн тухай тунхаглал батлагдсаны 25 жилийн ойг тохиолдуулан “Эмнести Интернэйшнл” олон улсын байгууллагын Ерөнхий нарийн бичгийн дарга, хатагтай Агнес Калламардаас илгээсэн захидал.)

А.Калламард: Хүндэт Улсын Их Хурлын дарга аа,

“Эмнести Интернэйшнл” /Amnesty International/ шударга бусын эсрэг 10 сая гаруй хүнийг нэгтгэсэн дэлхийн дахины хөдөлгөөн юм.

Бид хүн бүр эрхээ эдэлдэг дэлхийн ертөнцийн төлөө, үүний дотор дэлхий даяар хүний эрх хамгаалагчид аюулгүй орчинд үйл ажиллагаагаа явуулдаг байхын төлөө кампанит ажил өрнүүлдэг.

Олон улсын хүний эрх хамгаалагчдийн өдрийг тохиолдуулан би Монгол Улсын Их Хурлаас **2021 онд Хүний эрх хамгаалагчдын эрх зүйн байдлын тухай хуулийг баталж Азидаа анхдагч орон болсонд гүнээ талархаж байгаага илэрхийлж байна.**

Монгол Улс хүний эрх, үндсэн эрх чөлөөг хамгаалах, хөхиүлэн дэмжих үйлсэд хүний эрх хамгаалагчдын оруулж байгаа хувь нэмрийг хүлээн зөвшөөрч 2022 онд уг хуулийг хэрэгжүүлэх механизмыг амжилттай байгуулсанд **“Эмнести Интернэйшнл” сайшааж байна.**

Түүнчлэн 2023 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий ассамблейн 78 дугаар чуулганаар хүний эрх хамгаалагчдын асуудлаарх тогтоолыг өргөн мэдүүлэхэд Монгол Улс хамтран оролцсон явдалд **“Эмнести Интернэйшнл” талархаж байна.**

Цаашид Монгол Улсын Их Хурлаас хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуулийг практикт үр дүнтэй хэрэгжүүлэхэд анхаарч ажиллана гэдэгт **“Эмнести Интернэйшнл” итгэж байна.**

Энэ хуулиар хүний эрх хамгаалагчдыг бүрэн хамгаалахын тулд хүний эрх зөрчигчдөд хариуцлага тооцохыг шаардсан идэвхтний дуу хоолойг боомилж болзошгүй хуулийн цоорхойгоо арилгаж хүний эрх хамгаалагчдад тайван замаар үйл ажиллагаагаа явуулах аюулгүй орчныг бүрдүүлэхийг **“Эмнести Интернэйшнл”-ээс уриалж байна.**

Хүний эрхийн түгээмэл тунхаглал батлагдсаны 75 жилийн ойг тохиодуулан бид Монгол Улсын Их Хурлаас хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөртөө хүний эрхийг хамгаалах болон албан бус боловсролын тогтолцоонд нэгтгэх тухай удирдамж бүхий хүний эрхийн боловсролын дэлхийн хөтөлбөр болон хүний эрхийн боловсрол, сургалтын тухай Нэгдсэн Үндэстний Байгууллагын тунхаглалын дагуу хүний эрхийн боловсрол олгох асуудлыг тусган манлайлж дахин Азидаа анхдагч орон болохыг уриалж байна.

Хүний эрхийг түгээн дэлгэрүүлэх, хамгаалах, бодитойгоор эдлүүлэхэд хүний эрхийн боловсрол чухал хувь нэмрээ оруулдаг.

Монгол Улс нь хүний эрхийн боловсролыг зөвхөн бага, дунд, дээд боловсролын тогтолцоонд заахаас гадна цагдаа, хуулийн мэргэжилтнүүд, шүүх, захиргааны байгууллагын ажилтнууд зэрэг төрийн бүх албан хаагч, албан тушаалтныг хүний эрхийн боловсрол, сургалтаар үргэлжлүүлэн хангах ёстой.

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүний эрхийн зөвлөлөөс 2011 оны 03 дугаар сарын 23-ны өдөр баталсан Хүний эрхийн боловсрол, сургалтын тухай Нэгдсэн Үндэстний Байгууллагын тунхаглалаар хүний эрх, үндсэн эрх чөлөөг хүндэтгэх явдлыг дэмжих зорилгоор хүн бүр боловсрол эзэмших эрхтэй гэдгийг дахин баталгаажуулсан билээ.

Мөн улс орнууд хүний эрхийн боловсрол, сургалтыг дэмжих, явуулах үндсэн үүрэгтэй болохыг зарлан тунхагласан. Энэ тунхаглал нь улс орнуудын зүгээс хүний эрхийн

боловсролыг тууштай дэмжиж байгаагаа харуулах гол баталгаа юм.

Бид **“Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 75 жилийн ой”**-г тохиолдуулан Монгол Улс бүс нутгийн хэмжээнд хүний эрхийн боловсрол олгогч, бодлого боловсруулагчдад зориулж олон улсын жишигт нийцсэн хүний эрхийн боловсролыг түгээх, суралцах хамтын ажиллагааны Азийн хүний эрхийн боловсролын төв байгуулах амлалт авахыг уриалж байна.

Монгол Улс нь үндэсний болон бүс нутгийн хэмжээнд хүний эрхийг хүндэтгэсэн нийгмийн соёлыг төлөвшүүлж бүх нийтээр хүндэтгэн сахих явдлыг хөхиүлэн дэмжих хүчин чармайлтаа эрчимжүүлэх ёстой.

Гүнээ хүндэтгэсэн Агнес Калламард.

“Эмнести Интернэйшнл”-ийн Ерөнхий нарийн бичгийн дарга. /алга ташив/

Г.Занданшатар: “Эмнести Интернэйшнл” олон улсын байгууллагын Ерөнхий нарийн бичгийн дарга, хатагтай Агнес Калламард танд талархал илэрхийлье.

Хүний эрхийн түгээмэл тунхаглал батлагдсаны 75 жилийн ойд зориулсан энэ ойн хүрээнд мэндчилгээ дэвшүүлж, баяр хүргэсэн, ололт амжилтыг онцлон тэмдэглэсэн, бас цаашдаа хамтын ажиллагаа, тусламж дэмжихээ илэрхийлсэн, бас үнэтэй зөвлөмж өгсөн нийт олон улсын байгууллагууд, Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий ассамблейн дарга, Нэгдсэн Үндэстний

Байгууллагын Хүний эрхийн дээд комиссар, Нэгдсэн Үндэстний Байгууллагын суурин төлөөлөгчийн газар Тапан Мишра, “Эмнести Интернэйшнл” байгууллагын нийт удирдлагуудад Улсын Их Хурлын гишүүдийн нэрийн өмнөөс гүн талархал илэрхийлье. /алга ташив/

Ингээд хүндэтгэлийн хуралдаанд оролцсон Монгол Улсын Ерөнхий сайд Лувсаннамсрайн Оюун-Эрдэнэ, Улсын Их Хурал, Засгийн газрын эрхэм гишүүд, үе үеийн Улсын Их Хурлын дарга нарын төлөөлөл өнөөдрийн хуралдааны зохион байгуулахад санаачилж идэвхтэй оролцсон Намбарын Энхбаяр, Санжбэгзийн Төмөр-Очир, Дамдины Дэмбэрэл нарын Улсын Их Хурлын дарга нарын төлөөлөл, Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллагуудын дарга, удирдлагууд, Хүний эрхийн Үндэстний Комиссын дарга, гишүүд, Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга, мөн хүний эрхийг хамгаалах үйлсэд үнэтэй хувь нэмэр оруулж байгаа иргэдийн төлөөллүүд, Монгол Улсад суугаад дипломат төлөөлөгчийн газрын тэргүүн нар, Нэгдсэн Үндэстний Байгууллага, түүний төрөлжсөн олон улсын байгууллагын Монгол Улс дахь суурин төлөөлөгчид Та бүхэнд гүн талархал илэрхийлье. /алга ташив/

Хүний эрхийн түгээмэл тунхаглал батлагдсаны 75 жилийн ойд зориулсан Улсын Их Хурлын хүндэтгэлийн хуралдаан өндөрлөснийг мэдэгдье. /алх цохив/

Хуралдаан 42 минут үргэлжилж, 12 цаг 22 минутад өндөрлөв.

**БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ
БУУЛГАЖ, ХЯНАСАН:
ШИНЖЭЭЧ**

Ц.АЛТАН-ОД